

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

“Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” аудит

АУДИТЫН КОД: НАГ-2021/01-1-ШТА-ТД

Аудитын 1 дүгээр хэлтэс

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер
Ц.Бат-Өлзий
Ахлах аудитор Д.Ичин
Аудитор С.Лхагвасүрэн, У.Оюунхүү
Д.Мөнхдэлгэр
Гэрээт ажилтан Д.Зэндмэнэ

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө
Г корпус 524 дүгээр өрөө. Утас:11315578

Улаанбаатар хот
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн	5
БҮЛЭГ 1. Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх..	6
БҮЛЭГ 2. Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх	7-8
БҮЛЭГ 3. Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх.....	9
АУДИТЫН ДҮГНЭЛТ	10
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	11
Хавсралтууд.....	12-13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2021 оны А/28 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2021 оны төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулан нийслэлийн ИТХ-д хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх;
- Зарлагыг бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх;
- Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Нийслэлийн 2022 оны төсвийн төсөл, түүний танилцуулга, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийг хамруулан аудит хийв. Аудитын талбарын ажлын хүрээнд Нийслэлийн ЗДТГ, Татварын газар, Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Хөрөнгө оруулалтын газар, Автозамын хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар зэрэг байгууллагуудаас судалгаа авч дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” болон батлагдсан заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад Төсвийн тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл болон холбогдох заавар, журмуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Нийслэлийн Засаг дарга Нийслэлийн 2022 оны төсвийн төслийг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн Нийслэлийн 2022 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Аудитын нэгдүгээр хэлтсийн дарга, аудитын менежер Ц.Бат-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор Д.Ичин хэрэгжүүлж, аудитор У.Оюунхүү, С.Лхагвасүрэн, Д.Мөнхдэлгэр, гэрээт ажилтан Д.Зэндмэнэ нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд нийслэл, дүүргийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг нийт 1,642,414.5 сая төгрөгөөр төсөвлөжээ.

Улаанбаатар хотын төсөвт татварын орлогоор 263,102.7 сая, татварын бус орлогоор 191,476.3 сая, дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлгээр 727,039.1 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 14,353.4 сая, өмнөх оны үлдэгдлээс 353,700.2 сая, төсвийн байгууллагуудын өөрийн орлогоор 13,111.4 сая, нийт 1,562,783.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэл, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу

- Улсын төсөвт төвлөрч байсан ААНОАТ-ын 40 хувийг нийслэлийн төсөвт,
- Нийслэлийн төсөвт төвлөрч байсан ХХОАТ, ҮХЭХАТ болон газрын төлбөрийн орлогыг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр болсон.

Орон нутгийн төсвийн татварын орлоготой холбоотой дээрх онцлог өөрчлөлтийн үр дүнд өмнөх онд нийслэлийн төсвөөс 4 дүүрэгт 28,655.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан бол 2022 онд 3.6 дахин буурч 2 дүүрэгт 7,989.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр, 5 дүүргээс 125,055.3 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлж байсан бол дүн нь 5.8 дахин өсөж 7 дүүргээс 727,039.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр байна.

Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд орлогын боломжит эх үүсвэрийг дайчлахаар тэмдэгтийн хураамжаас бусад татварын болон татварын бус нэр төрлийн дийлэнх орлогыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 10-40 орчим хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь нийслэлийн төсвөөс олгосон хөрөнгийн эх үүсвэрээр 2014-2017 онд нийт 123 хадгаламж зээлийн хоршоонд 2 жилийн хугацаатай 14,307.8 сая төгрөгийн зээл олгож, 2017 онд “Бичил бизнесийг дэмжих сан”-гийн удирдлагын шийдвэрээр зээлийн эргэн төлөлтийн хугацааг 3 жилээр сунган нэмэлт гэрээ байгуулжээ.

2021 оны 9 сарын байдлаар уг зээлийн үндсэн төлбөрийн 7,927.6 сая, хүүгийн 61.8 сая, нийт 7,989.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2022 онд уг авлагын 20%-ийг барагдуулахад нийслэлийн төсвийн орлогыг 1,598.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.


БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАРЛАГА БУУРУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

Нийслэлийн 2022 онд төсвийн төсөлд 9 дүүргийн суурь зарлагыг 219,183.3 сая төгрөгөөр тооцож төсөвлөсөн бөгөөд Улаанбаатар хотын урсгал зардлыг 479,222.1 сая, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэгт 160,021.4 сая, 2 дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэгт 7,989.3 сая, нийслэлийн төсвийн болон автозамын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад 915,550.3 сая, хотын төсвөөс нийт 1,562,783.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Хотын төсвийн нийт урсгал зарлагын төсвийн төлөвлөгөөг байгууллага бүрээр, зардлын нэр төрлөөр харьцуулахад 2022 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Нийслэлийн салбар зөвлөлийн төсөвт тавилга худалдан авахад 24.1 сая, Нийслэлийн ИТХ болон ЗДТГ-ын төсөвт зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 520.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Энэ нь 2022 оны төсвийг боловсруулахад Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн бодлогын хүрээнд бүх шатны төсвийн захирагч тавилга худалдан авах, зочин төлөөлөгч хүлээн авах зэрэг зардлыг 100 хувь хэмнэх бодлого, зарчимд нийцэхгүй байгаа тул дээрх зардлуудыг хасаж **544.1** сая төгрөгөөр бууруулахыг санал болгож байна.

Улаанбаатар хотын төсвөөс шууд санхүүждэг 45 орчим байгууллагын нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлын жил бүрийн төлөвлөгөөг 2018 онтой харьцуулахад 2019 онд 1.6 дахин, 2020 онд 2.6 дахин, 2021 онд 1.9 дахин өсжээ.



2022 оны төсвийн төсөлд нэг удаагийн тэтгэмж, урамшууллын дээрх зардлыг 1,511.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь “Жишиг өрхийн эмнэлгийн барилга” барих өртөгтэй тэнцэхүйц хөрөнгө байгаа бөгөөд үүнээс 80% буюу 1,201.8 сая төгрөгийг нь зөвхөн Нийслэлийн ИТХ, ЗДТГ зарцуулахаар төсөвлөжээ.

Иймд төсвийн урсгал зардлыг хэмнэх, бүх шатны байгууллагууд хэмнэлтийн горимд ажиллахаар төлөвлөсөн бодлогод нийцүүлэн нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлыг **700.0** сая төгрөгөөр бууруулж 2018 оны түвшинд төлөвлөхийг санал болгож байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнээс 562,101.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцээгүй байна. Үүнд:

- Шинээр эхлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилах зарчмыг баримтлахгүйгээр 2 жилд хэрэгжүүлэх 339,848.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 81,225.3 сая төгрөг төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹-д заасан шаардлагад нийцээгүй; (*Хавсралт 1*)
- Хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад төсөл, арга хэмжээний байршил, хүчин чадал тодорхойгүй 159,186.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг, орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний жагсаалтад 5,176.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “бусад” гэсэн нэршлээр, тодорхойгүй 1 арга хэмжээг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6² дах заалтад тус тус нийцээгүй; (*Хавсралт 2*)
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 57,889.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³ нийцээгүй байна. (*Хавсралт 2*)

Хөрөнгө оруулалтын бус шинжтэй тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихээргүй 9 ажлыг хасаж хэрэгжүүлэгч байгууллагын урсгал зарлагын төсөвт тусгах, төсөвлөлтийн зарим шаардлагыг хангаагүй 19 төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь дахин эрэмбэлж шаардлагатай эсэхийг тодорхойлох, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх ажлыг тодорхой тусгах зэргээр хуулийн шаардлагад нийцүүлэн зохицуулалт хийх шаардлагатай.

¹ 29.3.5. “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах”

² 33.2.6. “Төсөвт ...хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг ... тусгаж, батална”

³ 4.1.24. “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

2020 оны гүйцэтгэлээр нийслэлийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар 18, хаалттай болон хувьцаат компани 5, нийт 23 хуулийн этгээдээс зөвхөн 5 буюу 22% нь ашигтай, бусад нь алдагдалтай ажилласан байна.

Тухайлбал “Багахангайн мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-т нийслэлийн төсвөөс жил бүр 60 орчим сая төгрөгийн санхүүжилт олгож байгаа бөгөөд тухайн үйлдвэрийг Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанаас 2013 оны 5 дугаар сард бүхэлд нь битүүмжилснээс хойш үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа явагдаагүй байна.

2021 оны байдлаар урт хугацаат 5,508.5 сая, богино хугацаат 468.1 сая, нийт 5,976.6 сая төгрөгийн өр төлбөр, 615.4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайландаа тусгасан боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгө, бараа материал биетээр бүрэн байгаа эсэхийг тооллого хийх баталгаажуулах боломжгүй байдалтай байна. Иймд тус үйлдвэрийн газрын шүүхийн шийдвэртэй холбоотой асуудлыг хуулийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК, “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалтын менежмент” ХХК-ийн зарим чиг үүрэг ижил төстэй, давхардсан байна. Үүнд:

Д/д	"Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент" ХХК	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК
Давхардаж буй чиг үүрэг 1	“Нийслэлийн Хөгжлийн Сан”, “Нийслэлийн Ногоон Сан” гэх хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулж, сангийн хөрөнгийг гэрээний дагуу удирдах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх.	НИТХ-аас зөвшөөрөгдсөн бусад орлого зэргээр хөгжлийн сан бүрдүүлэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх.
Давхардаж буй чиг үүрэг 2	Нийслэл хотын ногоон хөгжлийг дэмжсэн, эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн томоохон төслүүдэд урт хугацаатай, уян хатан нөхцөл бүхий санхүүжилт хийснээр Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн өсөлт хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах.	Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн стратегид тусгагдсан зарим төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлэх.

Чиг үүрэг нь давхардаж буй дээрх хуулийн этгээдийг нэгтгэснээр жил бүрийн урсгал зардлыг хэмнэх, үр ашгийг сайжруулах боломж байна.

Нөгөө талаар Компанийн тухай хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хувьд хаалттай хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компани тул цаашид өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг баримтлах чиглэлд анхаарах, нийслэлийн төсвөөс нэмж санхүүжилт олгохгүй байх шаардлагатай.

Нийслэлийн төсвийн орлогод орон нутгийн өмчит 5 хуулийн этгээдээс төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэн 50 хувиар тооцож төсөвлөсөн боловч алдагдалтай ажиллаж байгаа хуулийн этгээдийн алдагдлыг бууруулах, чиг үүргийн давхардлыг арилгах, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй байна.

Иймд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа, чиг үүргийг хувийн хэвшил хэрэгжүүлэх боломж, төрийн оролцооны шаардлага зэргийг харгалзан нэгтгэх, татан буулгах, хувьчлах зэргээр алдагдлыг бууруулах, засаглал, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг цогцоор төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд орлогын боломжит эх үүсвэрийг дайчлахаар тэмдэгтийн хураамжаас бусад татварын болон татварын бус нэр төрлийн дийлэнх орлогыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 10-40 орчим хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.
2. Нийслэлийн төсвийн эх үүсвэрээр хадгаламж зээлийн хоршоодод олгосон зээлийн хүү болон үндсэн төлбөрийн авлагаас тодорхой хувийг барагдуулснаар орлогыг 1,598.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
3. Төсвийн урсгал зардлыг хэмнэх, тэвчиж болох зардлыг танах бодлогын хүрээнд тавилга худалдан авах, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлыг нийт 1,244.1 сая төгрөгөөр бууруулах шаардлагатай байна.
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршил, хүчин чадлыг тодорхой тусгах, олгох санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилах зэрэг төсөвлөлтийн зарим шаардлагыг хангаагүй 504,212.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 арга хэмжээг төлөвлөжээ.
5. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 57,889.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй байна.
6. Нийслэлийн төсвийн орлогод орон нутгийн өмчит 5 хуулийн этгээдээс төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэн 50 хувиар тооцож төлөвлөснөөс өөрөөр орон нутгийн өмчит хуулийн этгээдийн алдагдлыг бууруулах, чиг үүргийн давхардлыг арилгах, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

1. Орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, хадгаламж зээлийн хоршоодод олгосон зээлийн авлагын үлдэгдлээс барагдуулах зорилгоор төсвийн орлогыг 1,598.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх.
2. Төсвийн урсгал зардлыг хэмнэх, тэвчиж болох зардлыг танах бодлогын хүрээнд тавилга худалдан авах, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлыг нийт 1,244.1 сая төгрөгөөр бууруулах.
3. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй 9 ажлыг хэрэгжүүлэгч байгууллагын урсгал зарлагын төсөвт тусгах, төсөвлөлтийн зарим шаардлагыг хангаагүй 18 төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж хуулийн шаардлагад нийцүүлэн зохицуулалт хийх.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа, чиг үүрэг, хувийн хэвшил хэрэгжүүлэх боломж, төрийн оролцооны шаардлага зэргийг харгалзан нэгтгэх, татан буулгах, хувьчлах зэргээр алдагдлыг бууруулах, засаглал, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөж Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

**Хэрэгжүүлэх хугацаанд санхүүжилтийг тэнцүү хуваарилах шаардлагыг
хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт**

Д/д	Төсвийн төслийн жагсаалтад тусгагдсан дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Хэрэгжүүлэх хугацаа	2022 онд санхүүжүүлэх дүн (сая.төг)		
			Эхлэх	Дуусах			Хуулийн дагуу төлөвлөх	Төсвийн төсөлд төлөвлөсөн	Зөрүү буюу дутуу төлөвлөсөн
	1	2	3	4	5	6	7=5/6	8	9=7-8
1	24.1.2-16	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, 9ш /Улаанбаатар хот/	2022	2023	41,186.9	2 жил	20,593.5	10,000.0	10,593.5
2	24.1.1 5-13	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар хот/	2022	2023	30,000.0	2 жил	15,000.0	11,500.0	3,500.0
3	24.1.1 9-6	Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэн /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг/	2022	2023	12,000.0	2 жил	6,000.0	3,000.0	3,000.0
4	24.1.2 -22	Нийслэлийн Наркологийн эмнэлгийн барилга /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо/	2022	2024	10,573.0	3 жил	3,524.3	2,000.0	1,524.3
5	24.1.1 5-14	Хан-Уул дүүргийн 8р хорооны орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар хот ХУД/	2022	2023	10,000.0	2 жил	5,000.0	4,000.0	1,000.0
6	24.1.1 9-10	Хан Хилс хотхон орчмын тохижилтын ажил Туул голын эргийн дагуух тохижилтын ажил /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо/	2022	2023	9,553.6	2 жил	4,776.8	2,405.0	2,371.8
7	24.1.1 6-2	Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгуулам, Улаанбаатар хот ХУД	2022	2023	3,300.0	2 жил	1,650.0	559.3	1,090.7
Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт									
8	2	Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, гүүрний барилга	2022	2023	119,000.0	2 жил	59,500.0	24,761.0	34,739.0
9	1	Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, замын байгууламж	2022	2023	64,965.2	2 жил	32,482.6	10,000.0	22,482.6
10	35	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо/	2022	2023	10,100.0	2 жил	5,050.0	4,000.0	1,050.0
11	33	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/	2022	2023	9,723.4	2 жил	4,861.7	3,000.0	1,861.7
12	34	Сургуулийн барилга, 640 суудал /СХД, 30 дугаар хороо/	2022	2023	9,723.4	2 жил	4,861.7	3,000.0	1,861.7
13	36	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо/	2022	2023	9,723.4	2 жил	4,861.7	3,000.0	1,861.7
		Нийт			339,848.9		168,162.3	81,225.3	86,937.0

Тайлбар: Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 "Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах"

**Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, байршил, хүчин чадлын талаарх
мэдээллийг тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт**

Д/д	Төсвийн төслийн жагсаалтад тусгагдсан дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг (сая.төг)	Тайлбар
			Эхлэх	Дуусах		
	1	2	3	4	5	6
1	24.1.15-20	Хот, хот орчмын ногоон байгууламж, тохижилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил Улаанбаатар хот/	2022	2022	64,000.0	Байршил тодорхойгүй
2	24.1.2-16	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, 9 ш /Улаанбаатар хот/	2022	2023	41,186.9	Байршил, хүчин чадал тодорхойгүй
3	24.1.19-7	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалтын ажил	2022	2022	18,000.0	Байршил тодорхойгүй
4	24.1.2-32	Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хийж, хотын зээлжих зэрэглэлийг тогтоох ажил	2022	2023	5,000.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
5	24.1.15-15	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн ажил, / Улаанбаатар хот/	2022	2023	5,000.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
6	24.1.2-23	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, чадваржуулах, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ	2022	2022	1,200.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
7	24.1.15-27	Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд дүгнэлт гаргах, паспортжуулах ажил	2022	2022	565.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
8	24.1.15-28	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд олон нийтэд нээлттэй болгох ажил /Улаанбаатар хот/	2022	2022	200.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
9	24.2-1	Нийслэлийн Онцгой байдлын газарт шаардлагатай гал түймэр унтраах даралтын хоолой	2022	2022	114.4	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт						
10	32	Нүхэн гарц, гүүрэн байгууламж, авто зам дагуух тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын ажил	2022	2022	20,000.0	Байршил тодорхойгүй
11	30	Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх бэлтгэл ажил	2022	2022	19,500.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
12	25	Уулзваруудын дахин инженерчлэл	2022	2022	18,000.0	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
13	31	Гараж, хайс хашлага буулгаж, чөлөөлсөн газар дээрх нөхөн сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил, зөвлөх үйлчилгээ	2022	2022	16,000.0	Байршил тодорхойгүй
14	26	Авто зогсоол шинээр барих, шинэчлэх, менежментийг сайжруулах, төлөвлөлтийг дахин зохион байгуулах ажил	2022	2022	8,319.6	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай
Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалт						
15	XI	Бусад	2022	2022	5,176.9	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тодорхойгүй
		Нийт			222,252.8	

Тайлбар: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24. "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; 33 дугаар зүйлийн 33.2 Төсөвт дараах зүйлийг тусгаж батална. 33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/